



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨВ ЗҮТГЭЭ!

№96 (96)

2021.07.22

ЦАХИМ ШУУДАНД

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДАД ТАЛАРХСАН СЭТГЭЛЭЭ ИЛЭРХИЙЛЭВ

Ардын хувьсгалын 100 жил, БХЯ үүсэн байгуулагдсаны 110 жилийн ойг тохиолдуулан БХЯ-ны "Дайчин алдар" медалийг БНӨСУ-ын энхийг сахиулах ажиллагааг удирдахаар шинээр томилогдсон НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын тусгай /SRSG/ төлөөлөгч ноён Николис Хайсомд бригадын генерал Б.Эрдэнэбат гардуулж өглөө.



Энэ үеэр ноён Николис Хайсом Монгол Улс НҮБ-ын гишүүн орны хувьд олон улсын энх тайван аюулгүй байдлыг хангахад үнэтэй хувь нэмэр оруулж БНӨСУ-д явагдаж байгаа энхийг сахиулах ажиллагаанд цэргийн багаа илгээснээс хойш 9 жил болсон бөгөөд тус ажиллагааны халуун цэг болох Юнити мужид Монгол Улсын цэргийн баг мандатаар заагдсан үүргээ сайн гүйцэтгэж байгааг онцоллоо. Мөн тэрээр Батлан хамгаалахын сайдад талархсан сэтгэлээ илэрхийлээд цаашид байнга хамтран ажиллана гэлээ.

НИСДЭГ ТЭРЭГНИЙ АНГАРЫН ШАВИЙГ ТАВИЛАА

Зэвсэгт хүчний 303 дугаар анги

Тус ангийн 2020-2021 онд тусгагдсан томоохон ажлуудын нэг болох МТ-1001, МТ-1002 нисдэг тэрэгний "Ангар" барих ажил бөгөөд тус барилгын шав тавих хүндэтгэлийн ажиллагаа 7 дугаар сарын 20-ны өдөр болж өнгөрлөө.

Уг хүндэтгэлийн ажиллагаанд Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн удирдлага, нисэх инженер техникийн бүрэлдэхүүн болон "Жойнт актив" ХХК-ны компанийн удирдлага хамт олон, Гандан тэгчилэн хийдээс урилгаар лам нар оролцож ном хураилж ангар барих газрыг хөндөж хөрс хуулалтын ажлыг эхлүүлээ. Тус бүтээн байгуулалтын ажлыг 2021 ондоо багтаан 07 дугаар сарын 20-оос энэ оны 12 дугаар сарын 31-ны хооронд "Жойнт актив" ХХК-ны ажилчид хийж гүйцэтгэн хүлээлгэн өгөх аж.

Ангар нь олон улсын чанарын стандартад нийцсэн Нисгэгч

болон нисэх инженер техникийн бүрэлдэхүүний тав тухтай эрүүл аюулгүй орчин нөхцөлд ажиллах боломжийг бүрдүүлэхээс гадна тус ангид одоогоор ашиглагдаж байгаа 2 нисдэг тэрэгний ашиглалт эдэлгээний хугацаа уртсхаас гадна ангийн бэлэн байдлын зэрэг дээшлэх ач холбогдолтой юм.

Өвлийн нөхцөлд гадаа байдаг нисдэг тэргийг асаахад дор хаяж 2 цаг халааж байж нислэг үйлддэг байсан бол бид бүхэн ангартай болсноор нисдэг тэргийг шууд ангараас гаргаж цаг хугацаа алдалгүй түргэн шуурхай нислэг үйлдэх боломжтой болж байна. Мөн нисэх инженер техникийн бүрэлдэхүүн цаг агаарын хүнд нөхцөлүүдэд гадаа ажилладаг байсан бол дулаан ангартай болсноор нисдэг тэрэгний техник үйлчилгээнүүдийг цаг хугацаа алдалгүй түргэн шуурхай хийх боломж нөхцөлөөр хангагдах юм.



Нутгийн зүүн хагаст үүлэрхэг. Бусад нутгаар солигдмол үүлтэй. Төвийн аймгуудын нутгийн зүүн хэсэг, зүүн аймгуудын ихэнх нутаг, говийн аймгуудын нутгийн зарим газраар бороо, дуу цахилгаантай аадар бороо орно.

Салхи нутгийн зүүн хэсгээр баруун өмнөөс, бусад нутгаар баруун хойноос секундэд 6-11 метр, говь, тал, хээрийн нутгаар секундэд 13-15 метр, нутгийн зарим газраар борооны өмнө түр зуур ширүүснэ.


Монгол-Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтэйн уулархаг нутаг, Хүрэнбэлчир орчим, Туул, Тэрэлж, Хэрлэн, Онон голын хөндийгөөр

21-26 градус, Их нууруудын хотгор болон говийн бүс нутгийн баруун болон зүүн хэсгээр 31-36 градус, бусад нутгаар 25-30 градус дулаан байна.

Улаанбаатар хот орчмоор: Үүл багасна. Бороо орохгүй. Салхи баруун хойноос секундэд 5-10 метр. 22-24 градус дулаан байна.

Багануур орчмоор: Үүлэрхэг. Бороо орно. Салхи баруун хойноос секундэд 6-11 метр. 23-25 градус дулаан байна.

Тэрэлж орчмоор: Үүлэрхэг. Бага зэргийн бороо орно. Салхи баруун хойноос секундэд 5-10 метр. 21-23 градус дулаан байна.



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 149,773 +1319	ЭДГЭРСЭН 137,602 +3501	НАС БАРСАН 745 +5
-----------------------------------	---------------------------	----------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 3895 +67	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 252 +17	ЭДГЭРСЭН 3574 +25
-----------------------------	--------------------------------	----------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 192,215,741
Эдгэрсэн Нийт: 174,915,658
Нас барсан Нийт: 4,133,136

Хэрэв Та бие тань тавгүйрхсэн эсвэл гэртээ тусгаарлагдаж байгаа бол энэ нэгэнтэй уулзахаас татгалзаарай. Ингэснээр Та халдварын гинжин хэлхээг таслахад чухал үүрэг гүйцэтгэнэ.



ТАНЫ БИЕ ТАВГҮЙ БАЙВАЛ ГЭРЭЭСЭЭ БИТГИЙ ГАРААРАЙ!

ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 13
2021.07.22 / ПҮРЭВ ГАРАГ

ЗУНЫ ДУНД ХӨХӨГЧИН ХОНЬ САРЫН ГУРВАН ХӨХ ЦАГААГЧИН ХОНЬ ӨДӨР

Үс засуулбал:

Жаргал ирнэ

Наран ургах, шингэх:
05:16-20:41

Барилдлага:

Үл зохилдох

Шүтэн барилдлага:

Авахуй

Суудал:

Огторгуй

Аргын тооллын долдугаар сарын 22, Бархасвадь гараг. Билгийн тооллын 13, Суулга одтой, цагаагчин хонь өдөр.

Тухайн өдөр гахай, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн.

Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй. Лус тахих, мал худалдан авах, мал түгээх, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Цөөрөм байгуулах, сахил санваар авах, хануур, төөнүүр, хийлгэх, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу.

Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал ирнэ.

СПОРТ

ТОКИО-2020 олимпын наадамд оролцох “Алдар” спорт хорооны тамирчдыг цувралаар танилцуулж байна.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ “АЛДАР” СПОРТ ХОРООНЫ ЖУДО БӨХИЙН ТАМИРЧИН МУГТ, ДЭСЛЭГЧ ӨЛЗИЙБАЯРЫН ДҮҮРЭНБАЯР



Дэслэгч Өлзийбаярын Дүүрэнбаяр нь 1994 оны 1 дүгээр сарын 31 нд Улаанбаатар хотод төрсөн. Ам бүл 4 хэнэр 2 хүүхдийн хамт амьдардаг. 1-5-р ангиа Оросын холбооны улсын Улан-Үдэ хотын 26 дугаар дунд сургууль, ахлах сургуулиа Улаанбаатар хотын “Галакси” бүрэн дунд сургуулийг 2012 онд алтан медальтай төгссөн.

2012-2016 онд “Аварга” Биеийн тамирын дээд сургуулийг багш дасгалжуулагч мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн.

Жудо бөхийн спортоор 2006 оноос хичээллэж эхэлсэн. 2010 онд

Жудо бөхийн залуучуудын Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

Спортын дэд мастер цол 2011 онд

Спортын мастер цол

Жудо бөхийн Залуучуудын улсын аварга

шалгаруулах тэмцээнээс мөнгөн медаль 2012 онд

Жудо бөхийн Монгол туургатны аварга шалгаруулах тэмцээнээс мөнгөн медаль

Жудо бөхийн ‘Taiepei orep’-олон улсын тэмцээнээс мөнгөн медаль

Жудо бөхийн залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

Самбо бөхийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

Жудо бөхийн залуучуудын Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

БНСУ-ын Чечу Дэлхийн цомын тэмцээнээс хүрэл медаль

2013 онд Жудо бөхийн “Насанд хүрэгчдийн Багийн Улсын аварга” шалгаруулах тэмцээнээс мөнгөн медаль

Жудо бөхийн ‘Wojin cup’ залуучуудын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

Жудо бөхийн насанд хүрэгчдийн багийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

Жудо бөхийн “Asian orep Taiepei” олон улсын залуучуудын аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль

Инчеоны Азийн зуны 17дахь их наадмын мөнгөн медаль

АНУ-ын Маями хотноо зохиогдсон залуучуудын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс мөнгөн медаль

Жудо бөхийн ‘Wojin cup’ залуучуудын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

Жудо бөхийн ‘Shonhor cup’ оюутны аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

Жудо бөхийн залуучуудын Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

Славян улсад зохиогдсон Залуучуудын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс мөнгөн медаль

Улаанбаатар Гран при тэмцээнээс хүрэл медаль

Олон улсын хэмжээний мастер цол 2014 онд

Жудо бөхийн ‘Wojin cup’ залуучуудын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

Жудо бөхийн насанд хүрэгчдийн багийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

Жудо бөхийн “Asian orep Taiepei” олон улсын залуучуудын аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль

Qindao Grand Prix олон улсын тэмцээнээс хүрэл медаль

Жудо бөхийн ‘Hong kong international Judo Tournament’ олон улсын насанд хүрэгчдийн аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

Жудо бөхийн Зүүн азийн аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль

Инчеоны Азийн зуны 17дахь их наадмын мөнгөн медаль

АНУ-ын Маями хотноо зохиогдсон залуучуудын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс мөнгөн медаль

Жудо бөхийн насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

Жудо бөхийн насанд хүрэгчдийн багийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль

Chinggis Khan Judo Grand Prix тэмцээнээс мөнгөн медаль

Швейцар улсын Цюрих хотноо зохион байгуулагдсан Дэлхийн Цэргийн жудо бөхийн аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль, багийн хүрэл медаль

Qindao Grand Prix олон улсын тэмцээнээс мөнгөн медаль

Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль

Qindao Grand Prix олон улсын тэмцээнээс мөнгөн медаль

Франц улсын Парис хотноо зохиогдсон Их дуулга тэмцээнээр хүрэл медаль

Ази тивийн аваргын хүрэл медаль

Арабын нэгдсэн Имират улсын Абу Даби хотноо зохиогдсон Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс мөнгөн медаль

Насанд хүрэгчдийн жудо бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

Хөх хотын Гран при тэмцээнээс мөнгөн медаль

Индонез улсын Жакарта хотноо зохиогдсон Азийн тоглолтоос мөнгөн медаль

Азербайжан улсын Баку хотноо зохиогдсон насанд хүрэгчдийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс Зэвсэгт хүчний хэмжээнээс анхны хүрэл медаль хүртсэн.

2019 онд ХБНГУ-ын Дюзельдорф хотноо зохиогдсон Их Дуулга тэмцээнээс хүрэл медаль хүртсэн юм.

Зуны 32 дахь “Токио-2020” олимпын тоглолт энэ 7-р сарын 23-наас эхэлж, 8-р сарын 8 хүртэл явагдахаар болсон бөгөөд түүнд дэлхийн 200 гаруй улс орноос, спортын 33 төрлөөр, 339 медалийн төлөө өрсөлдөж юм байна.

Монгол Улсын 43 тамирчин “Токио-2020” олимпод спортын 10 төрөлд өрсөлдөх бөгөөд манай тамирчдаас хэн хэн, спортын ямар төрөлд, хэзээ өрсөлдөх хуваарийг доорх хүснэгтээс харна уу.

тэмцээнээс Монгол улсад анхны алтан медаль

Чех улсын Прага хотноо зохиогдсон Дэлхийн цомын тэмцээнээс хүрэл медаль 2015 онд

Польш улсын Варшав хотноо зохиогдсон Дэлхийн цомын хүрэл

Жудо бөхийн ‘Undes cup’ оюутны аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

Жудо бөхийн насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс мөнгөн медаль

Улаанбаатарын Гран При тэмцээнээс хүрэл медаль 2016 онд

Жудо бөхийн насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс мөнгөн медаль

Жудо бөхийн оюутны улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

Жудо бөхийн насанд хүрэгчдийн багийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль

Chinggis Khan Judo Grand Prix тэмцээнээс мөнгөн медаль

Швейцар улсын Цюрих хотноо зохион байгуулагдсан Дэлхийн Цэргийн жудо бөхийн аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль, багийн хүрэл медаль

Qindao Grand Prix олон улсын тэмцээнээс мөнгөн медаль

Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль

Qindao Grand Prix олон улсын тэмцээнээс мөнгөн медаль

Франц улсын Парис хотноо зохиогдсон Их дуулга тэмцээнээр хүрэл медаль

Ази тивийн аваргын хүрэл медаль

Арабын нэгдсэн Имират улсын Абу Даби хотноо зохиогдсон Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс мөнгөн медаль

Насанд хүрэгчдийн жудо бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

Хөх хотын Гран при тэмцээнээс мөнгөн медаль

Индонез улсын Жакарта хотноо зохиогдсон Азийн тоглолтоос мөнгөн медаль

Азербайжан улсын Баку хотноо зохиогдсон насанд хүрэгчдийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс Зэвсэгт хүчний хэмжээнээс анхны хүрэл медаль хүртсэн.

2019 онд ХБНГУ-ын Дюзельдорф хотноо зохиогдсон Их Дуулга тэмцээнээс хүрэл медаль хүртсэн юм.

Зуны 32 дахь “Токио-2020” олимпын тоглолт энэ 7-р сарын 23-наас эхэлж, 8-р сарын 8 хүртэл явагдахаар болсон бөгөөд түүнд дэлхийн 200 гаруй улс орноос, спортын 33 төрлөөр, 339 медалийн төлөө өрсөлдөж юм байна.

Монгол Улсын 43 тамирчин “Токио-2020” олимпод спортын 10 төрөлд өрсөлдөх бөгөөд манай тамирчдаас хэн хэн, спортын ямар төрөлд, хэзээ өрсөлдөх хуваарийг доорх хүснэгтээс харна уу.

ИХ МАСТЕР Б. МӨНГӨНТУУЛ ДЭЛХИЙН ЦОМЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНЭЭ ӨНДӨРЛӨЛӨӨ



ОХУ-ын Сочи хотноо “Дэлхийн цом-2021” болон “Эмэгтэйчүүдийн дэлхийн цом- 2021” өндөр зэрэглэлийн тэмцээнийг 2021 оны долдугаар сарын 12-ны өдрөөс наймдугаар сарын 6-нд Дэлхийн шатрын холбоо /ДШХ/ ноос зохион байгуулж байна.

Монгол Улсаа төлөөлөн “Дэлхийн цом-2021”-д Их мастер Д.Батсүрэн, ОУМ С.Ган-Эрдэнэ, “Эмэгтэйчүүдийн дэлхийн цом 2021”-д Их мастер Б.Мөнгөнтуул, ОУМ Т.Мөнхзул нарын шилдэг шатарчид өрсөлдөж байгаа юм.

Тус тэмцээнд “Алдар” спорт хороо, Үндэсний шигшээ багийн тамирчин, Их мастер Б.Мөнгөнтуул нийт 6 өрөг тоглохдоо 4 өрөгт нь өрсөлдөгч наара илт давуугаар ялсан амжилттайгаар тэмцээнээ өндөрлөлөө.

Тодруулбал, Украин улсын тамирчин, Их мастер Осьмак Юлияг 2:0 оноогоор илт илүүрхэн буулгаж авснаар тэмцээний шилдэг 32-т багтаж, дараагийн гурвын даваанд дэлхийн од, ОХУ-ын тамирчин, Их мастер Лагно Екатеринай хүч үзсэн юм. Түүний хувьд энэ удаагийн тоглолтуудаа урд өмнө тоглож байгаагүй шинэ гараанууд бэлдэж тоглосон юм. Энэ нь өрсөлдөгчийн өргийг судлах, дүн шинжилгээ

хийх, тоглолтын тактик боловсруулах, гарааны сонголт хийх гэх мэт зүйлст маш их хүч хөдөлмөр, цаг хугацаа зарцуулсан алхмууд байсан юм.

Хоёр жил тутамд зохион байгуулдаг тус тэмцээнд дэлхийн 100 гаруй орны шилдэг шатарчид оролцдог бөгөөд “Дэлхийн цом -2021”-д 206, “Эмэгтэйчүүдийн дэлхийн цом-2021”-д 103 шилдэг шатарчин оюун ухаанаа уралдуулж байгаа юм.

Хасагдах системээр 8 даваа буюу бүрэн матч, даваа бүрд цагаан, хар талаас тус бүр үндсэн стандарт 1 өрөг тоглож, оноо тэнцсэн тохиолдолд рапид, блиц төрлүүдээр мөн адил цагаан, хар талаас тус бүр 1 өрөг тоглон хайнагаа хагалж тогложноор аваргуудаа шалгаруулах юм.

Энэ жилийн дэлхийн цом тэмцээн нь өндөр зэрэглэлийн тэмцээнд оролцогчдын тоог нэмэгдүүлэн хамрах хүрээгээ тэлж, шагналыг санг 50 хувиар өсгөж, Дэлхийн цом тэмцээний дэргэд анхдугаар “Эмэгтэйчүүдийн дэлхийн цом 2021” Аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, хувцаслалтын өндөр дэг журам мөрдөж буй гэдгээрээ өмнөх цомын Аварга шалгаруулах тэмцээнүүдээс онцлогтой юм.

ЦАГ ҮЕ

Файзерын вакцины татан авалт гурав, дөрөвдүгээр улиралд үргэлжилнэ



Япон улсын Засгийн газрын санхүүжилтээр НҮБ-ын Хүүхдийн сангаас зохион байгуулж буй 2.35 сая тун Файзерын вакцин худалдан авч Монгол Улсад нийлүүлэх ажил өнгөрсөн сарын 16-наас эхэлсэн бөгөөд өнөөдөр зургаа дахь татан авалтаа хийлээ.

Өнөөдрийн татан авалтаар нийт 92 490 тун Файзерын вакцин ирсэн бөгөөд энэ сарын 28-нд дахин 132 210 тун вакцин хүлээн авахаар төлөвлөж байна. Одоогоор нийт зургаан удаагийн татан авалтаар, 417 690 тун хүлээн аваад байгаа юм.

Ийм байдлаар Файзерын вакциныг худалдан авч нийлүүлэх ажил энэ оны гурав ба дөрөвдүгээр улирал дуустал үргэлжлэх тул цаашид 12-17 насны нийт 290 мянга орчим хүүхэд, жирэмсэн эхчүүд болон вакцинд хамрагдаагүй бусад иргэдийг бүрэн вакцинжуулах нөөц бүрдэх юм.

Монгол Улсад өнөөдрийн байдлаар, нэг сая 860 мянга 497 хүн коронавирустай эсрэг вакцины хоёр тун хийлгэсэн бөгөөд нийт хүн амын 57.2 хувь нь вакцинаа бүрэн хамрагджээ.

МОНГОЛ ТАМИРЧИД ОЛИМПОД

БАЙТ ХАРВАА:

- Эрэгтэй: Б.Отгонболд, 07.23-нд,
- Эмэгтэй: Б.Урантунгалаг, 07.23-нд,

ЖУДО:

- Эрэгтэй: 60 кг-д Д.Амартүвшин, 07.24-нд, 66 кг-д Ё.Басхүү, 07.25-нд, 73 кг-д Ц.Цогтбаатар, 07.26-нд, 81 кг-д Сайид Моллай, 07.27-нд, 90 кг-д Г.Алтанбагана, 07.28-нд, -100 кг-д Л.Отгонбаатар, 07.29-нд, +100 кг-д Ө.Дүүрэнбаяр, 07.30-нд,
- Эмэгтэй: 48 кг-д М.Уранцэцэг, 07.24-нд, 52 кг-д Л.Сосорбарам, 07.25-нд, 57 кг-д Д.Сумъяа, 07.26-нд, 63 кг-д Б.Ганхайч, 07.27-нд, 78 кг-д О.Мөнхцэцэг, 07.28-нд,

БОКС:

- Эрэгтэй: 57 кг-д Э.Цэндбаатар, 07.24-нд, 63 кг-д Б.Чинзориг, 07.25-нд,
- Эмэгтэй: 75 кг-д М.Мягмаржаргал, 07.28-нд,

УСАНД СЭЛЭЛТ:

- Эрэгтэй: М.Дэлгэрхүү, 07.31-нд,
- Эмэгтэй: Б.Энххүслэн, 07.31-нд,

ШИРЭЭНИЙ ТЕННИС:

- Э.Лхагвасүрэн, 07.24-30-нд,
- Б.Болор-Эрдэнэ, 07.24-30-нд,

ХҮНДИЙГ ӨРГӨЛТ:

- Эмэгтэй: +87 кг-д Э.Билэгсайхан, 08.02-нд, 87 кг-д М.Анхцэцэг, 08.02-нд,

БУУДЛАГА:

- Эмэгтэй, хийн гар буу, спорт гар буу. О.Гүндэгмаа, 07.25-нд, 07.29-30-нд, Ц.Анударь, 07.25-нд, 07.29-30-нд, О.Есүгэн, 07.25-нд, 07.29-30-нд, Эрэгтэй, хийн гар буу, хурдан буудлага. Э.Даваахүү, 07.24-нд, 08.01-02-нд, Холимог багийн буудлага 07.27-нд.

ЧӨЛӨӨТ БӨХ:

- Эрэгтэй: 57 кг-д Э.Бэхбаяр, 08.04-нд, 125 кг-д Х.Болортуяа, 08.05-нд, 65 кг-д Т.Тулга, 08.06-нд,
- Эмэгтэй: 76 кг-д О.Бурмаа, 08.01-нд, 68 кг-д С.Батцэцэг, 08.02-нд, 62 кг-д Х.Болортуяа, 08.03-нд, 57 кг-д Б.Хонгорзул, 08.04-нд, 53 кг-д Б.Болортуяа, 08.05-нд, 50 кг-д Ц.Намуунцэцэг, 08.06-нд,

МАРАФОН:

- Б.Мөнхзаяа, 08.07-нд,
- Б.Сэр-Од, 08.08-нд,
- Ц.Бямбажав, 08.08-нд,

САГСАН БӨМБӨГ (3х3):

(О.Хулан, М.Цэрэнлхам, Э.Чимэддолгор, Б.Солонго, Б.Болор-Эрдэнэ, Д.Ганзул) Монголын цагаар

- 07.24-нд: Монгол- Итали, 16.30 цагт
- 07.24-нд: Монгол – АНУ, 20.00 цагт
- 07.25-нд: Монгол- Япон, 09.15 цагт
- 07.25-нд: Монгол – ОХУ, 15.00 цагт
- 07.26-нд: Монгол – Румын, 11.40 цагт
- 07.26-нд: Монгол – Франц, 16.30 цагт
- 07.27-нд: Монгол – БНХАУ, 12.55 цагт